

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 4-р сарын 29

Тендер шалгаруулалтын нэр: “Гэрээт харуул хамгаалалт (2 багц)” үзүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012394

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос “Гэрээт харуул хамгаалалт (2 багц)” үзүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйлчилгээний тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

*Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 оны аль нэг жилд гүйцэтгэсэн ажлын борлуулалтын орлого тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна.*

*Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2018, 2019 оны санхүүгийн тайлан аудитаар баталгаажсан байх ба дүгнэлтийн хамт ирүүлэх.*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Шаардлагатай.

Тендерийн хамт:

- Багц-1-д 8,159,760 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа,
- Багц-2-т 3,366,815 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Тендерийг 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 11:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 11:10 цагт цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Зөвшөөрөхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 406 тоот өрөө,  
утас: 450060 + 115

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ